| Томилох эрх бүхий албан тушаалтан нь: | |
|---|---|
| Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | 2024 оны 1 сард байгууллагын ажиллагсдын эрхэмлэн ажиллах (Гурван 3, Гурван Х-ийн) зарчмыг боловсруулан баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд тус зарчмыг хэрэгжүүлснээр ажилтан бүр бие биедээ зөвлөн халамжлах, зөвшилцөл, хамтын ажиллагаа, зөв харилцааг эрхэмлэн ажиллаж хэмлэн буруутгах, хов ярих, хэрүүл маргаанаас ангид байж Хамтын хүчээр ажиллаж хөдөлмөрлөх нөхцөл бүрдэж байна.<br><br> |
| Дэд хорооны үйл ажиллагаа, урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн чадавх бэхжүүлсэн талаар | ЭМС-ын 256 тоот тушаалыг үндэслэн Ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг цалингийн 10%, гишүүд 5% урамшууллыг тус тус авч байна. |
| Ёс зүйн зөрчил гарч байгаа болон үүсэж болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийсэн, эрсдэлийг бууруулахаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | 2024 онд ёс зүйн зөрчилтэй холбоотой эрсдэлийг үнэлж үйлчлүүлэгч болон ажилтантай холбоотой 2 дунд эрсдэлийг тодорхойлсон.<br>Эрсдэлийг бууруулахаар:<br>1. Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах зааврыг боловсруулж, ажлын байрны сургалтыг зохион байгуулсан.<br> |

| | |
|---|---|
| | 2. Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагыг үнэлэх сэтгэл зүйн тестийг авч сэтгэл судлаач ажиллуулахаар шийдвэрлэсэн. |
| Ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэх талаар тайлан, шийдвэрийн бүртгэл | Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй. |
| Ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ тайланг олон нийтэд тогтмол мэдээлсэн талаар | Үйл ажиллагааны мэдээ тайланг хагас жилийн байдлаар ЭМЯ-ны ёс зүйн хяналтын хороонд 7 сард мэдээлсэн. |
| **Ёс зүйн дэд хороо** | |
| Хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт болон өгсөн зөвлөмж | -2024 оны 8 сарын 20-нд Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх алба, хүний эрхийн комиссын хамтарсан "Авилгаас ангид байцгаая", "Хүний эрх ба ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 52 ажилтныг хамруулсан.<br>-4-6 сард сар бүрийн эхний долоо хоногт байгууллагын соёлын журмыг мөрдөх, хэцүү үйлчлүүлэгчтэй хэрхэн харьцах, байгууллагын эрхэмлэн ажиллах зарчмыг хэвшүүлэх чиглэлээр ажлын байрны сургалтыг явуулсан.<br>-Байгууллагын дотоод цахим хуудсаар ажиллагсдад ёс зүйн зөвлөмж болон ЭМС-ын 2019 оны А/406 тоот тушаал: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг цувралаар хүргэсэн.<br><br> |
| УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн | - ЦССҮТ-ийн эрхэм зорилго, алсын хараанд нийцүүлэн, төвийн эмч нийт ажиллагсад хоорондоо |

| | |
|---|---|
| албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | болон үйлчлүүлэгчтэй зөв харилцах, байгууллагын соёлыг хэвшүүлэх зорилгоор 2024 оны 4 сард "СЭТГЭЛЭЭ ЖОЛООДОЖ -ХҮНДЛЭЛИЙГ ТҮГЭЭЕ" аяныг зохион байгуулсан.<br>Уг аяны ажиллагсдад мэдлэг, мэдээлэл түгээх зорилт-1-ийн хүрээнд 4 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн.<br>Ажиллагсдад эерэг дадлыг хэвшүүлэх зорилт-2-ийн хүрээнд 3 ажлыг төлөвлөн тус тус хэрэгжүүлсэн. |
| Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол мэдээлэл түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэл | Тайлант хугацаанд албан хаагчийн ёс зүйн асуудлаар нэг гомдол ирсэн боловч ёс зүйн зөрчил гэж шийдвэрлээгүй болно. Гомдолтой хамаарал бүхий ажилтнуудтай ганцаарчилсан уулзалт хийж, уг гомдол нь 2017 онд болсон үйл явдалтай холбоотой ба гомдолд тусгасан зүйл үндэслэл бүхий биш гэж үзэж гомдлыг шийдвэрлэж хаасан. |
| Дэд хорооны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн тайлан | 2024 оны 1 сард 14 ажил бүхий төлөвлөгөө ёс зүйн салбар хороогоор хэлэлцүүлэн баталсан. Төлөвлөгөөний биелэлт 93% байна. |
| Гомдол мэдээллийг хянан шалгасан дүгнэлт | 2024-03-07-нд ЦССҮТ-ийн захиргаанд нэг гомдол ирсэн ба хянан шалгаж ёс зүйн зөрчил биш гэж дүгнэсэн. |
| Дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлын мэдээ | Дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдол бүртгэгдээгүй. |

Биелэлт гаргасан: Ч.Жаргалмаа /ёс зүйн дэд хорооны нарийн бичиг/

Хянасан: М.Цэрэндэжид /ёс зүйн дэд хороон дарга/